



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ӨНДӨРШИЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 31 өдөр

Дугаар 2/66

Бөхт

Шууд гэрээ байгуулах эрх олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, Монгол Улсын Засгийн Газрын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 124 дүгээр тогтоол, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 87 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны хөрөнгө оруулалтаар хийгдэх “Хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх ажил”-ыг 9,000,000 (есөн сая) төгрөгөөр аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний газар, Хурын шим төвтэй шууд гэрээ байгуулсугай.

2. “Хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх ажил”-ыг судалгаа, тооцоололд үндэслэн үр дүнтэйгээр гүйцэтгэхийг “Аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний газар”-ын дарга (Э.Азжаргал)-д даалгасугай.

3. “Аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний газар”-тай шууд гэрээ байгуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Амгаланжаргал)-д, ажлын уялдааг хангаж, гүйцэтгэлийн хяналт тавьж ажиллахыг Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн (Х.Уугандорж) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



У.АЛТАНХҮҮ